



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ГОМБОЖАВЫН ГАНБОЛД ТАНАА

2020.09.03. № 087-2020/06-НА-44
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Сүхбаатар сумаас бие даан нэр дэвшигч Гомбожавын Ганболдын мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Сүхбаатар сумаас бие даан нэр дэвшигч Г.Ганболд нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020737

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Г.Ганболдын Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Г.Ганболдын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.


Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2020 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ГОМБОЖАВЫН ГАНБОЛДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



- Эх орны ирээдүй болсон эх нялхас, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, өсвөр залуу үеийг эх орноор бахархах сэтгэхүйг дэмжиж, хүүхэд багачуудын эрүүл мэнд, боловсролыг хөгжүүлэх чиглэлд түлхүү анхаарч “Ирээдүйн иргэн” хөтөлбөрийг аймгийн хэмжээнд боловсруулан, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Ялгаварлан гадуурхлыг арилгах, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тархины саажилттай хүүхдүүдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн болон хамгааллын төвүүдийг дэмжиж ажиллана.
- Ард иргэдийн нийтээр цэвэр, цэмцгэр орчинд амьдрах боломжийг бүрдүүлэх “Тохилор орчин” төсөл, хөтөлбөрийг боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг болон мал хамгаалах, тариалан эрхлэлтийг дэмжих хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангуудын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шударга зарчимд нийцүүлэн, хөдөлмөр эрхлэгч иргэдийг дэмжих бодлого баримтлан ажиллана.
- Ахмадуудыг туршлага мэдлэгээ хуваалцах сайн дурын ажил эрхлэх боломжоор ханган, нийгмийн оролцоог дэмжиж ахмадуудад зориулсан олон нийтийн арга хэмжээ, нийгмийн үйлчилгээг цогцоор хөгжүүлэхэд анхаарч ажиллана.
- Асран хамгаалах хүнгүй өндөр настныг ганцаардал, сэтгэл санааны гутрал зэргээс урьдчилан сэргийлэх халамжийн төвийг байгуулах төр болон хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- Орон нутгийн брэнд болох Сэлэнгэ талх, загас, эсгий болон годон гутлыг үйлдвэрлэгчдийн холбоог дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- Хувийн хөрөнгөөр спортын талбай, цогцолбор, төвөөс алслагдсан багт барьсан аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- “Гудамж” төслийг үргэлжлүүлэн, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар аймгийн хэмжээнд “Хашаандаа тохилор амьдаръя” дэд төсөл боловсруулж, хувийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Залуу болон хүүхэдтэй гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлж, нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх бодлогыг дэмжинэ.
- Жимс жимсгэнэ тариалах, үр суулгацаар хангах замаар жимсний аж ахуйн салбарыг бий болгоход бүх талаар дэмжиж ажиллана.

Бие даагч

Г.Ганболд

2020-07-23